# ХААН СОЁМБО АУДИТ ХХК

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2023/47/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2023 он


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн чанарын хяналт, ахлах аудитор: Н.Бадамханд
Утас: 99042699 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1.Аудитын санал дүгнэлт....3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....5

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....7

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....11

3. Аудитын тайлан....12

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....12

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин....12

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....12

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд....13

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....13

4. АУДИТЫН ТАЙЛАН....14

4.1 Ерөнхий зүйл....14

4.2 Материаллаг байдал....14

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт....15

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....15

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....15

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....15

4.5.1 Завсрын аудитын талаар....15

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал....16

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....16

3.8 Аудитын гол асуудал....16

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....16

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....16

4. Аудитын илрүүлэлт....16

4.1 Залруулсан алдаа....16

4.2 Төлбөрийн акт....16

4.3 Албан шаардлага....16

4.4 Зөвлөмж....16

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл....16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.15 № 01/68
танай ____________ -ны № ____________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАНЗРАГЧ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын барилга нь насжилт өндөртэй Мэргэжлийн хяналтын дүгнэлтээр ашиглах боломжгүй, ашиглалтын хугацаа дууссан барилга гэж дүгнэлт гарсан байна.

**Аудитын гол асуудал**

Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтаар 21.4 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймгийн Засаг даргатай байгуулж, хэрэгжилтийг 85.7 хувьтай гүйцэтгэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **325,355,894.10** | **495,574,850.85** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 121,688,816.22 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 121,688,816.22 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 121,688,816.22 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 121,688,816.22 |
| **33** | **АВЛАГА** | 606,206.65 | 00.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 604,076.65 | 00.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 2,130.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 324,749,687.45 | 373,886,034.63 |
| **351** | **Түүхий эд материал** | 00.00 | 2,545,050.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 00.00 | 2,545,050.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 324,749,687.45 | 371,340,984.63 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 00.00 | 26,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 971,000.00 | 705,500.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.00 | 140,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 00.00 | 1,235,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 323,778,687.45 | 369,234,384.63 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **496,436,935.82** | **448,979,668.97** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 496,436,935.82 | 448,979,668.97 |
| **392** | **Биет хөрөнгө** | 389,600,068.38 | 341,503,268.89 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,329,375,512.54 | 1,329,551,223.54 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,095,183,827.33 | -1,118,000,940.53 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 34,900,000.00 | 34,900,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -7,634,375.07 | -11,996,875.11 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 98,364,562.08 | 110,862,562.08 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -13,522,163.33 | -26,629,157.65 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 36,964,550.01 | 6,507,400.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -32,454,772.03 | -984,013.32 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 255,683,540.00 | 253,545,140.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -216,892,958.49 | -236,252,070.12 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 106,836,867.44 | 107,476,400.08 |
| 39301 | Программ хангамж | 2,839,670.00 | 4,042,600.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -222,802.56 | -1,035,199.92 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 104,220,000.00 | 104,469,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **821,792,829.92** | **944,554,519.82** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **821,792,829.92** | **944,554,519.82** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 821,792,829.92 | 944,554,519.82 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 629,565,915.31 | 629,814,915.31 |
| 51101 | Өмч: - төрийн | 629,565,915.31 | 629,814,915.31 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -93,692,904.33 | 28,883,310.46 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -93,692,904.33 | -93,629,379.44 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 122,512,689.90 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 285,919,818.94 | 285,856,294.05 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **821,792,829.92** | **944,554,519.82** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,008,889,256.00** | **1,194,518,529.98** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **74,096,756.00** | **48,229,329.98** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 70,946,766.00 | 48,229,329.98 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 70,946,766.00 | 25,004,130.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 25,004,130.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 70,946,766.00 | 00.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 3,149,990.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 3,149,990.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **934,792,500.00** | **1,146,289,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 00.00 | 889,937,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 889,937,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 8,964,500.00 | 49,690,800.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 200,000.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,934,500.00 | 27,657,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 5,400,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,830,000.00 | 16,633,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 925,828,000.00 | 206,661,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 925,828,000.00 | 206,661,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **995,336,351.28** | **1,072,005,840.08** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **995,336,351.28** | **1,072,005,840.08** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 936,932,394.85 | 1,022,648,725.54 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 592,514,648.20 | 614,940,469.65 |
| 210101 | Үндсэн цалин | 473,423,395.45 | 554,793,641.65 |
| 210102 | Нэмэгдэл | 119,091,252.75 | 60,146,828.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 77,958,982.75 | 77,039,823.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54,176,057.02 | 53,051,128.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,014,915.51 | 6,241,304.70 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,761,532.60 | 4,925,843.94 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,181,202.90 | 1,161,834.04 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,825,274.72 | 11,659,711.92 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 173,129,463.08 | 174,445,615.46 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,159,460.60 | 4,396,090.06 |
| 210302 | Түлш, халаалт | 167,342,070.48 | 167,342,069.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,627,932.00 | 2,707,456.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,804,361.34 | 15,987,358.78 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,152,350.00 | 1,174,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,439,200.00 | 6,623,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,619,662.89 | 1,760,244.78 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 177,000.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 872,200.00 | 758,500.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 10,543,948.45 | 5,490,014.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,986,000.00 | 7,219,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,986,000.00 | 7,219,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 754,000.00 | 3,047,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 754,000.00 | 3,047,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,573,510.00 | 47,189,919.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,496,500.00 | 46,185,726.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 79,500.00 | 119,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 437,500.00 | 00.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 495,000.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 312,010.00 | 311,993.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 65,211,429.48 | 82,779,539.65 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 4,923,772.80 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 137,900.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 65,073,529.48 | 77,855,766.85 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 58,403,956.43 | 49,357,114.54 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 57,165,800.00 | 41,482,300.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 51,725,800.00 | 40,714,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,440,000.00 | 768,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,238,156.43 | 7,874,814.54 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,238,156.43 | 7,874,814.54 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **13,552,904.72** | **122,512,689.90** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 2,533,000.00 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 2,533,000.00 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -2,533,000.00 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **11,019,904.72** | **122,512,689.90** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1,129,565,915.31 | 289,357,410.91 | -47,951,018.81 | 1,370,972,307.41 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,129,565,915.31** | **289,357,410.91** | **-47,951,018.81** | 1,370,972,307.41 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -49,684,887.01 | -49,684,887.01 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **629,565,915.31** | **285,919,818.94** | **-93,692,904.33** | 821,792,829.92 |
| D01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **629,565,915.31** | **285,919,818.94** | **-93,692,904.33** | 821,792,829.92 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 63,524.89 | 63,524.89 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **629,565,915.31** | **285,919,818.94** | **-93,629,379.44** | 821,856,354.81 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -63,524.89 | 00.00 | -63,524.89 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 249,000.00 | 00.00 | 00.00 | 249,000.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 122,512,689.90 | 122,512,689.90 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **629,814,915.31** | **285,856,294.05** | **28,883,310.46** | 944,554,519.82 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **935,292,500.00** | **1,171,295,460.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **25,006,260.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 25,006,260.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 25,006,260.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 25,006,260.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **935,292,500.00** | **1,146,289,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 00.00 | 889,937,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 889,937,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 9,464,500.00 | 49,690,800.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 200,000.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,934,500.00 | 27,657,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 5,400,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,330,000.00 | 16,633,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 925,828,000.00 | 206,661,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 925,828,000.00 | 206,661,200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **930,452,500.00** | **1,027,537,143.78** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **930,452,500.00** | **1,027,537,143.78** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **872,046,413.57** | **978,180,029.24** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 593,118,712.68 | 614,336,393.00 |
| 210101 | Үндсэн цалин | 468,288,108.35 | 555,145,940.35 |
| 210102 | Нэмэгдэл | 124,830,604.33 | 59,190,452.65 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 77,958,994.92 | 77,039,823.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54,171,869.19 | 53,055,328.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,019,115.51 | 6,237,104.70 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,761,532.60 | 4,925,843.94 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,181,202.90 | 1,161,834.04 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,825,274.72 | 11,659,711.92 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 173,129,463.08 | 174,445,615.46 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,159,460.60 | 4,396,090.06 |
| 210302 | Түлш, халаалт | 167,342,070.48 | 167,342,069.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,627,932.00 | 2,707,456.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,740,862.89 | 10,035,444.78 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,000,000.00 | 917,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,194,200.00 | 6,405,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,619,662.89 | 1,760,244.78 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 177,000.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 750,000.00 | 771,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,667,600.00 | 8,675,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,667,600.00 | 8,675,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 754,000.00 | 3,047,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 754,000.00 | 3,047,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,538,880.00 | 83,991,753.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,461,870.00 | 82,987,560.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 79,500.00 | 119,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 437,500.00 | 00.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 495,000.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 312,010.00 | 311,993.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 137,900.00 | 6,608,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 6,608,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 137,900.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **58,406,086.43** | **49,357,114.54** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 57,165,800.00 | 41,482,300.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 51,725,800.00 | 40,714,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,440,000.00 | 768,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,240,286.43 | 7,874,814.54 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,238,156.43 | 7,874,814.54 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **4,840,000.00** | **143,758,316.22** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **4,840,000.00** | **22,069,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **4,840,000.00** | **22,069,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 4,840,000.00 | 22,069,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 4,840,000.00 | 22,069,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-4,840,000.00** | **-22,069,500.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 121,688,816.22 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 121,688,816.22 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | 0.00 | - |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,132,086,100.00 | 992,044,029.24 | 90,354,270.76 | 87.60 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 1,132,086,100.00 | 992,044,029.24 | 90,354,270.76 | 87.60 |
| Бараа, үйлчилгээний зардал | 1,090,603,800.00 | 950,561,729.24 | 90,354,270.76 | 87.20 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 706,681,400.00 | 614,336,393.00 | 92,345,007.00 | 86.93 |
| Үндсэн цалин | 581,478,800.00 | 555,145,940.35 | 26,332,859.65 | 95.47 |
| Нэмэгдэл | 107,802,600.00 | 59,190,452.65 | 48,612,147.35 | 54.91 |
| Унаа, болон бусад нөхөн олговор | 17,400,000.00 | - | 17,400,000.00 | - |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 88,454,600.00 | 77,039,823.00 | 11,414,777.00 | 87.10 |
| Тэтгэврийн даатгал | 60,246,500.00 | 53,055,328.40 | 7,191,171.60 | 88.06 |
| Тэтгэмжийн даатгал | 7,083,700.00 | 6,237,104.70 | 846,595.30 | 88.05 |
| ҮОМШӨ ний даатгал | 5,653,500.00 | 4,925,843.94 | 727,656.06 | 87.13 |
| Ажилгүйдлийн даатгал | 1,406,500.00 | 1,161,834.04 | 244,665.96 | 82.60 |
| Эрүүл мэндийн даатгал | 14,064,400.00 | 11,659,711.92 | 2,404,688.08 | 82.90 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 181,063,400.00 | 174,445,615.46 | 6,617,784.54 | 96.35 |
| Гэрэл цахилгаан | 4,490,200.00 | 4,396,090.06 | 94,109.94 | 97.90 |
| Түлш, халаалт | 173,342,100.00 | 167,342,069.40 | 6,000,030.60 | 96.54 |
| Цэвэр, бохир ус | 3,231,100.00 | 2,707,456.00 | 523,644.00 | 83.79 |
| Байрны түрээс | - | - | - | - |
| Хангамж, бараа материалын зардал | 6,074,700.00 | 6,012,644.78 | 62,055.22 | 99.00 |
| Бичиг хэрэг | 917,800.00 | 917,800.00 | - | 100.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Тээвэр (шатахуун) | 2,383,100.00 | 2,383,100.00 | - | 100.00 |
| Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 1,793,800.00 | 1,760,244.78 | 33,555.22 | 98.13 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 180,000.00 | - | 100.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 800,000.00 | 771,500.00 | 28,500.00 | 96.44 |
| Нормативт зардал | 315,000.00 | - | 315,000.00 | - |
| Нормын хувцас зөөлөн эдлэл | 315,000.00 | - | 315,000.00 | - |
| Эд хогшил худалдан авах | 9,500,000.00 | 8,243,300.00 | 1,256,700.00 | 87.50 |
| Багаж, техник, хэрэгсэл | 4,500,000.00 | 4,500,000.00 | - | 100.00 |
| Урсгал засвар | 5,000,000.00 | 3,743,300.00 | 1,256,700.00 | 74.90 |
| Томилолт, зочны зардал | 1,555,400.00 | 1,329,000.00 | 226,400.00 | 85.40 |
| Дотоод албан томилолт | 1,555,400.00 | 1,329,000.00 | 226,400.00 | 85.40 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 56,959,300.00 | 49,998,453.00 | 6,960,847.00 | 87.80 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 55,775,100.00 | 48,994,260.00 | 6,780,840.00 | 87.80 |
| Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 720,000.00 | 540,000.00 | 180,000.00 | 75.00 |
| Даатгалын үйлчилгээ | 119,200.00 | 119,200.00 | - | 100.00 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 33,000.00 | 33,000.00 | - | 100.00 |
| Газрын төлбөр | 312,000.00 | 311,993.00 | 7.00 | 100.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 40,000,000.00 | 19,156,500.00 | 20,843,500.00 | 47.89 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 40,000,000.00 | 19,156,500.00 | 20,843,500.00 | 47.89 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 41,482,300.00 | 41,482,300.00 | - | 100.00 |
| Бусад урсгал шилжүүлэг | 41,482,300.00 | 41,482,300.00 | - | 100.00 |
| Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 40,714,300.00 | 40,714,300.00 | - | 100.00 |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 768,000.00 | 768,000.00 | - | 100.00 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,132,086,100.00 | 1,113,729,845.46 | 18,356,254.54 | 98.40 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 889,937,200.00 | 889,937,200.00 | | 100.00 |
| Улсын төсвөөс санхүүжих | 889,937,200.00 | 889,937,200.00 | - | 100.00 |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 206,661,200.00 | 198,786,385.46 | 7,874,814.54 | 96.19 |
| Орон нутгийн төсвөөс | 206,661,200.00 | 198,786,385.46 | 7,874,814.54 | 96.19 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 35,487,700.00 | 25,006,260.00 | 10,481,440.00 | 70.46 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 35,487,700.00 | 25,006,260.00 | 10,481,440.00 | 70.46 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | 0.00 | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 121,688,816.22 | (121,688,816.22) | - |
| ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | - |
| Төсвөөс гадуур байгууллага | - | - | - | - |
| АЖИЛЛАГСДЫН ТОО | 66.00 | 64.00 | 2.00 | 96.97 |
| Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| Гүйцэтгэх ажилтан | 49.00 | 47.00 | 2.00 | 95.92 |
| Үйлчлэх ажилтан | 16.00 | 16.00 | - | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **49,690,800.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **49,690,800.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 49,690,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,022,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,022,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,542,200.00 |
| 210602 | Тавилга | 610,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,932,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,718,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,718,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 38,407,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 38,407,800.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 49690800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 49,690,800.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 27,657,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,400,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 16,633,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театр нь нутгийн олон ястны ардын уламжлалт урлагийг мэргэжлийн түвшинд хөгжүүлэх, өвлүүлэх, уламжлуулах болон хөдөө орон нутгийн ард иргэдэд соёлын үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий мэргэжлийн урлагийн байгууллага бөгөөд Хөвсгөл аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм. Анх 1930 онд "Улаан гэр" нэртэйгээр үүсгэн байгуулагдаж, 1976 оноос "Хөгжимт драмын театр" болон орчуулгын хөгжимт, драмын жүжиг, дуурь, 50 гаруй хүүхдийн жүжиг, теле концерт, 3500 гаруй хүндэтгэлийн концертоор урын сангаа бүрэлдүүлэн ард иргэдэд урлагийн үйлчилгээг үзүүлж байна.

### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагын үндсэн мэдээлэл, түүний гадаад орчин болон дотоод үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл явцыг судалж, ойлгосноор эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Байгууллагад мөрдөгдөх дараах хууль тогтоомжуудад тайлант онд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

Дотоод хяналт, шалгалтын нэгжийг байгууллагын даргын 2022 оны Б/14 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна.

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын даргын дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгж нь 2022 оны төлөвлөгөөний дагуу байгууллагын хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуй орчны нөлөөлөл, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд хяналт шалгалт хийсэн байна.

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын барилга нь насжилт өндөртэй Мэргэжлийн хяналтын дүгнэлтээр ашиглах боломжгүй, ашиглалтын хугацаа дууссан барилга гэж дүгнэлт гарсан байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:*** Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн

бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсролын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөгжимт драмын театрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 122.8 сая төгрөгөөр буюу 7.3 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Дансны авлага | 0.6 | - | (0.6) |
| Бараа материал | 324.7 | 373.8 | 49.1 |
| Үндсэн хөрөнгө | 496.4 | 448.9 | (47.5) |
| Биет бус хөрөнгө | 106.8 | 107.4 | 0.6 |
| **Нийт хөрөнгө** | **821.7** | **944.5** | **122.8** |
| Дансны өглөг | - | - | - |
| -төрийн | 629.5 | 629.8 | 0.3 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 285.9 | 285.8 | (0.1) |
| Хуримтлагдсан үр дүн | (93.6) | 28.8 | 122.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **821.7** | **944.5** | 122.8 |

Тайлант онд дараах данстад өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Бараа материал 49.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авч бэлтгэсэн бараа материалын үлдэгдэл нөлөөлсөн байна.
2. Үндсэн хөрөнгө данс 47.5 сая төгрөгөөр багассан нь акталсан үндсэн хөрөнгө 9.3 сая төгрөг, тайлант оны элэгдлийн зардал 77.9 сая төгрөг байсантай холбоотой байна.
3. Хуримтлагдсан үр дүн нь тайлант оны үр дүн 122.4 сая төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,045.0 сая, нийт зарлагыг 1,045.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 199.6 сая төгрөгөөр бууруулж, 925.4 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 35.5 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 889.9 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 793.2 сая төгрөг буюу 85.7 хувьтай байгаа ба 7.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

*Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний зардал*

/сая төгрөгөөр/

| Хөтөлбөр, арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **71702** | **Хөгжимт драмын театр** | **925.4** | **793.3** | **17.02** | **85.7** |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 808.5 | 701.1 | 16.77 | 98.1 |
| 80214 | Уран бүтээлийн зардал | 40.0 | 39.3 | 0.7 | 98.2 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 41.5 | 41.5 | 0.0 | 100.0 |
| 83683 | Дээд шатны төсөв захирагчаас | 35.4 | 11.3 | 24.1 | 31.9 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагад 49.7 сая төгрөгийн нэмэлт орлого хүлээн авч тайлагнасан байна. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэхэд 16.6 сая төгрөг
- Аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны А/54, А/66, А/77 дугаар тушаалаар “Хөх сувд-2022” мөсний баярын бэлтгэл ажлын зардалд 16.2 сая төгрөг
- Аймгийн ЗД-ын 2022 оны А/211 дугаар захирамжаар баяр наадмын бэлтгэл ажлын зардалд 15.7 сая төгрөг
- Аймгийн ЗД-ын 2022 оны Б/35 дугаар захирамжаар хөгжимт драмын театрын уран бүтээлчид Улаанбаатар травел-2022 аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох үйл ажиллагааны зардал 1.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийг Төсвийн тухай хуулийн холбогдох заалтад заасны дагуу орлого хүлээн авч, холбогдох зардлын эрхийг нээлгэж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөгжимт драмын театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн чанарын хяналт, ахлах аудитор Н.Бадамханд гүйцэтгэж, хяналтыг анхан шатанд Хаан Соёмбо Аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор Б.Даваанял, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөгжимт драмын театрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн

тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт нийт зардлын 2 хувиар буюу 19.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 13.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 онд мэдээллийг оруулахдаа худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, цалингийн зардлаас бусад гүйлгээг үнэн зөв мэдээлсэн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хүрээнд шалгасан нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийн асуудал холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант онд Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрт завсрын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар байгууллагын бүртгэл, тайлагнал, материалын эмх цэгц, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 3 зөвлөмжийг өгч, тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 3 | 0 | 3 | 0 | 100 |
| **Нийт дүн** | 3 | 0 | 3 | 0 | 100 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 121.7 сая төгрөг харилцах дансанд үлдсэн байна.

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар санхүүгийн тайлагнал, анхан шатны баримт материал дутуу холбоотой 21.4 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн. Аудитаар залруулсан алдаа байхгүй.

### 5.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 5.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

### 5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Нягтлан бодох бүртгэлийн баримт бичигтэй холбоотой асуудал**

*1.1.* *<u>Илрүүлэлт:</u>* Анхан шатны баримтын бүрдлийн шаардлага хангахгүй баримтаар 21.4 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн, 13.7. *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”* заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*1.2.* *<u>Өгсөн зөвлөмж</u>*: Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Анхан шатны баримтын бүрдлийн шаардлага хангахгүй баримтаар гүйлгээ хийсэн | 1 | 21.4 | - | - | - | - | 1 | 21.4 | | | | |
| Дүн | 1 | 21.4 | - | - | - | - | 1 | 21.4 | - | - | - | - |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

| | |
|---|---|
| ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН: | |
| ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО: |
| АНХАН ШАТАНД ХЯНАСАН: | |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО: |
| АХЛАХ АУДИТОР | Б.ДАВААНЯМ ОГНОО: |
| БАТАЛГААЖУУЛСАН: | |
| ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН | |
| ЗАХИРАЛ | Х.ДИЙМАА |
| ЧАНАРЫН ХЯНАЛТ, АУДИТОР | Н.БАДАМХАНД |